



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/534

Чингис хот

“Талын түмэн адуу” эвент арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10, 16.1.12, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хоёрдугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд өвөл цагийн адуу маллах өвөрмөц уламжлал, адуу дагасан соёлыг хадгалж авч үлдэх, гадаад дотоодын жуулчдад сурталчлан таниулах, ирээдүй хойч үедээ өвлүүлэн эзэмшүүлэх зорилготой жил бүр зохион байгуулагддаг “Талын түмэн адуу” аялал жуулчлалын эвент арга хэмжээг арга хэмжээнд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012472